



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар A/75

Чойр

### Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 60.1.21, 74 дүгээр зүйлийн 74.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 32.1.10, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаваржилтын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан эрсдэлийг бууруулах зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Шуурхай штабын үйл ажиллагааг 24 цагаар тасралтгүй зохион байгуулж, төрийн байгууллагуудын харилцаан уялдааг ханган ажиллахыг Шуурхай штабын дарга (Б.Наранбаатар)-д үүрэг болгосугай.

3.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн сумдын малчдад өвс, тэжээл хүргэх, зам гаргах ажлыг зохион байгуулахыг Сумын Засаг дарга нарт, хорогдсон малын сэг зэм устгахад шаардагдах ариутгал, халдвартгүйтгэлийн бодис, мал, амьтны гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, вакцины нөөцийг яаралтай бүрдүүлэн ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (Ч.Отгонсүрэн)-д, малчдыг эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо шинжилгээнд бүрэн хамруулах, алслагдсан сумын малчдад эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Эрүүл мэндийн газрын дарга (Ц.Мөнх-Од)-д, цаг агаарын болон шар усны үерийн мэдээ, сээрэмжлүүлгийг иргэд олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай тогтмол хүргэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Х.Сүхбаатар), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Огтончимэг), Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Э.Энх-Од), "Тохижилт Сүмбэр" ОНӨААТУГ-ын дарга (Ц.Энхжаргал) нарт, цасанд боогдсон зам давааг чөлөөлөх, зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах ажлыг шуурхай зохион байгуулан ажиллахыг Цагдаагийн хэлтсийн дарга, (цагдаагийн хурандаа Ц.Баярхүү), Авто тээврийн үндэсний төвийн Говьсүмбэр аймаг дахь салбарын дарга (Н.Мөнхнаран), "Саруул харгуй" ХХК-ийн Чойр хэсгийн ахлах (Д.Гэрэлтуяа) нарт, хаваржилтын

500123 123

нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа, улирлын амралтын хуваарыт уян хатан зохицуулалт хийх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол шинжлэх ухааны газрын дарга (А.Зургаанжин)-д тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Шуурхай штабын дарга (Б.Наранбаатар)-д үүрэг болгосугай.



